



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 6/14

Дархан

Г Журам батлах тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Дархан хотын тохижилт үйлчилгээний газар ОНӨААТҮГ-ын ажилтан албан хаагч нарын ажлыг дүгнэх, ур чадварын нэмэгдэл олгох журам, ур чадварын үнэлгээний хуудсыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмыг үйл ажиллагаандaa мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг тус зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер /С.Мөнхбат/-д үүрэг болгосугай.

ГАЗРЫН ДАРГА

3. ЭРДЭНЭБАТ



Дархан хотын тохижилт үйлчилгээний газар
ОНӨААТУ Газрын Даргын 2025 оны 01 сарын
28.өдрийн бд! Утсийн тушаалын нэгдүгээр
хавсралт



**“ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР” ОНӨААТУ ГАЗРЫН
АЖИЛТАН АЛБАН ХААГЧ НАРЫН АЖЛЫГ ДҮГНЭХ, УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ
ОЛГОХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журмаар тус газрын Захирагаа удирдлагын хэлтэс, Санхүүгийн алба, Цахилгааны хэсэг, Авто хэсэг, Тохижилтын хэсэг, Зам талбайн хэсгүүдийн ажилтан албан хаагч нарын ажил гүйцэтгэх идэвх санаачлагыг дэмжиж, ур чадвар, ур бүтээлтэй ажиллуулах зорилгоор ур чадварын шалгуур үзүүлэлтийг тогтоож, үнэлэх, нэмэгдэл олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Ажил үүрэг гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгатай, ур бүтээлтэй ажилласан болон ёс зүйн зөрчилгүй, сахилгын шийтгэлгүй ажилтанд шалгуур үзүүлэлтийг баримтлан ур чадварын нэмэгдлийг олгоно.

1.3 Ажилтны ур чадварын нэмэгдлийг тогтоож, үндсэн цалингийн 10 хүртэл хувиар тооцож сар бүр олгоно.

1.4 Ур чадварыг үнэлж, дүгнэх, нэмэгдэл олгох үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, шударга байх зарчмыг баримтална.

1.5. Цалингийн сангаас хамаарч ажилтан албан хаагч нарын ажлыг дүгнэх, ур чадварын нэмэгдэл олгох журамд улиралд тутамд өөрчлөлт оруулж болно.

ХОЁР. АЖИЛТНУУДЫН АЖЛЫГ ДҮГНЭХ

2.1 Захирагаа удирдлагын хэлтэс, Санхүүгийн алба, Цахилгааны хэсэг, Авто хэсэг, Тохижилтын хэсэг, Зам талбайн хэсгүүдийн ажлыг сар бүр дүгнэж, үнэлгээг үндэслэн сарын сүүл цалинд нэмэгдлийг олгоно.

2.2 Хэлтэс, алба, хэсгийн дарга нар “Ажил дүгнэх үнэлгээний хуудас”-ны дагуу сар бүрийн 22-ны дотор дүгнэж танилцуулна

2.3 Хэлтэс, алба, хэсгийн дарга нар ажилтнуудаа сар бүр дүгнэж, Ерөнхий инженер танилцуулыг Газрын даргын зөвлөлийн хуралаар оруулж зөвлөлийн гарсан шийдвэрийг хүний нөөц нэгтгэн, ерөнхий нягтлан хянаж, газрын даргаар баталгаажуулна

2.4 Ажилтан албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг газрын даргын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн олгоно.

2.5 Газрын дарга нь албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох, үнэлгээг өөрчилж, ур чадварын нэмэгдэл олгохгүй байж болно.

ГУРАВ. УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

3.1. Ажилчдын ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар дүгнэнэ.

Үзүүлэлт	Оноо	Тайлбар
Ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийн хэрэгжилт	10	Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа эсэх.

Ажлын цаг ашиглалт	20	Мөн тухайн сардаа тасалсан хоног байхгүй тохиолдолд уг оноог авна. Мөн тухай сарын цаг ашиглалтын цахим бүртгэл болон, Газрын дарга, Ерөнхий инженер, хэлтэс, алба, хэсгийн дарга нарын санал үндэслэл.
Өгсөн үүрэг даалгаварын биелэлт	20	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг цаг тухайд нь чанартай биелүүлсэн байдлаас хамаарч уг оноог дүгнэнэ.
Ажилтны ёс зүй, сахилга хариуцлага	15	Ажлын байранд архидан согтуурах, архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ ажилдаа ирэх, нэгнийгээ хэл амаар доромжлох, үл тоох, ялгаварлан гадуурхах, зүй бус үйлдэл гаргасан тохиолдолд уг оноог ажилтан авах боломжгүй.
ХАБ хувцас хэрэглэл ашиглалт, аюулгүй ажиллагаа	10	ХАБ хувцас өмсөөгүй, аюулгүй ажиллагааны дүрмийг дагаж мөрдөөгүй тохиолдолд уг оноог авахгүй.
Байгууллагын өмч хөрөнгө, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт.	10	Байгууллагын эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалт, ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж, зохих журам, зааврын дагуу хэрэглэхийг шаардах,
Олон нийт ажилд оролцсон байдал	15	Аймаг, сум байгууллагаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээ, тэмцээн уралдаанд оролцсон оролцоо, хандлага.

ДӨРӨВ. УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ХУВЬ.

4.1 Хэлтэс, алба, хэсгийн дарга нар “Ажил дүгнэх үнэлгээний хуудас”-д заасан шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

4.2 Ур чадварын нэмэгдлийг ажилтны албан тушаалын нэг сарын үндсэн цалингийн 10 хуртэл хувиар тооцож олгоно.

4.3 Энэ журмын 3.2-т заасан ур чадварын нэмэгдлийг тухайн ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн дараах аргачлалаар тооцож олгоно. Үүнд:

д/д	Гүйцэтгэлийн үнэлгээ /оноо/	Ур чадварын нэмэгдлийн хувь
1	94-100	10 хувь
2	90-94	8 хувь
3	85-89	6 хувь
4	80-84	4 хувь
5	75-79	2 хувь

4.4 Дараах тохиолдолд ур чадварын нэмэгдэл олгохгүй.

4.4.1 Ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр 0-74 оноо авсан бол;

4.4.2 Нэг сард ажлын 15-аас дээш хоногийн хугацаагаар өвчтэй, чөлөөтэй байсан бол тухайн сард;

4.4.3 Туршилтын хугацаагаар ажиллаж буй ажилтанд;

4.4.4 Хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээ байгуулан ажиллаж буй иргэнд буюу гэрээт ажилтанд;

4.4.5 Газрын даргын тушаалаа сахилгын шийтгэл ногдуулсан ажилтанд;

4.4.5 Тухайн сарын ажлын ачаалал, гүйцэтгэл, үр дүнг харгалзан олгохгүй байж болно.

Ур чадварын үнэлгээний хуудас.

Ажилтны нэр		Ажил гүйцэтгэх чадвар					
		Ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийн хэрэгжилт					
		Ажлын цаг ашиглалт					
		Өгсөн үүрэг даалгаварын биелэлт					
НИЙТ		Ажилтны ёс зүй, сахилга хариуцлага	ХАБ хувцас хэрэглэл ашиглалт, аюулгүй ажиллагаа	Олон нийт ажилд оролцсон байдал Байгууллагын эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалт, ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж, зохих журам, зааврын дагуу хэрэглэхийг шаардах,	Нийт оноо /хувь /	Ур чадварын нэмэгдэл олгох хувь	Ур чадварын Нэмэгдлийн дүн